

Монгол Улсын Нийслэл түүний Засаг захиргааны хөгжилт

Монголчуудын өвөг болон XXII зууны Кидан нар 5 нийслэл /дээд, дорнод, дундад, өмнөд, өрнөд нийслэл/-тээ байсан гэдэг. VIII зууны үед Уйгар улсын цагт үүссэн эртний хотын суурин дээр үндэслэсэн Хархорин /Хархорин/ хотыг 1220 оны үед Чингис хаан өөрийн улсын нийслэл болгожээ.

Хархорин ингэж цэцэглэн байх цагт монгол гүрний нийслэлийг өөр газар шилжүүлэх санаачлага гарч Монголын Юан улсыг байгуулсан Хубилай хаан 1260-аад онд Кайпин /Шанцу/ Хан-балгас / Бээжин хотоор Их гүрний нийслэл болгожээ.

Юан улс мөхсөн 1368 оноос хойших үед Монгол улс өөрийн хүчиндээ тулгуурлах болсноос эхлэн Хархорин хот дахин Монгол овогтны улсын төв нь болжээ.

XV зууны үеэс Монголчууд баруун, зүүн гэж хуваагдахад Хархорин нь Зүүн Монголын төв болов. Ингээд XVI зууны эхэн үед Батмөнх даян хаан орд өргөөгөө Цахар нутагт суурьшуулснаар тус хот нь монгол овогтныг нэгтгэн баримтлан захирах төв нь байхаа больж шашин мөргөлийн төв болжээ.

XVIII зууны үе нь Монгол газар хямрал тэмцэл, дайн тулааны хөлд нэрвэгдэн нэгэн нутагт амар жимэр аж төрх, нэгэн хот суурингаа төвлөн суух янзгүй цаг байлаа. Тиймээс нийтийн төв болсон орд өргөөтэй гээ нүүдэллэх явдал олонтой болжээ.

Ийм нэгэн нүүдлийн хот нь Ар монгол /Халх/-ийн шашин мөргөл, улс төрийн төв болж ирсэн хүрээний үүсэл өргөө юм. Өргөө анх халх монголчуудын шашин мөргөлийн төв болон үүсжээ. Өргөө анх 1639 онд хэрхэн байгуулсан тухай сурвалж бичигт —Богд Жавзандамба гэгээнийг 5 сүүдэртэй байхад хөлгийн газрын 7 хошуу халх-ууд бүгдээрээ анх залж Ширээт Цагааннуур хэмээх газар гэгээн цол өргөөд шар бүсийн хот өргөж ширээнд суулгаж эрхэмлэн тахив..

Энэ жил дор олон газраас өвөр өврийн тайж албатаас гаргаж тусгайлан хар шавийг гаргаж байгуулж өгөвл хэмээв ээ.

Монголчууд эрт дээр үеэс ноёд эзний ордыг өргөө хэмээн нэрийдэн байсан бөгөөд тэр цагт Богдын суух орон байрыг нийтэд нь — Хутагтын өргөөл гэж нэрлэж байв. Өргөө нь эхэн үедээ таван хөлт их гэр, аймгуудын гэр /дуган/, Сан жагс, бурхан тахил ном-ийн гэрээс бүрдэж байлаа.

Өргөө нь хүрээ болсон цаг бол 1706 оны үеэс бөгөөд Цэцэрлэгийн Эрдэнэ толгой гэдэг газар Батцагаан буюу Рибогэжганцаншацуйлин хэмээх дуганыг дараа нь аймгуудын дуган нэмж байгуулжээ.1707 онд хүрээний хэргийг шийтгэх лам хар шавь нар бүгдийг захирах Шанзодбыг байгуулан тамга олгосноор хүрээ нь монгол дахь бусад олон хийдээс ялгарсан товойж —Их хүрээ хэмээн алдаршиж, түүнийг хятадууд /Да кулон/, төвд нар Хүрээ- чинь хэмээх болжээ.

Хүрээ өргөжиж байсан боловч мөн нүүсээр 1719- 1779 онуудад 21 удаа нүүж 1778 онд одоогийн байгаа газарт ирж суурьшсанаар хүрээний түүхийн суурин үе эхэлжээ. Хүрээ суурьшсан нутаг бол — Тунгалаг Туулын хөвөө, сэрүүн Сэлбийн дэнж, Хүн чулууны хонхор нэрт газар юм.

Их хүрээ өргөжин шинэ шинэ сүм дуган олныг байгуулсан бөгөөд 1772 онд Их хүрээ, 13 аймагтай байсан бол 1795 онд 27, 1903 онд 3 аймагтай болжээ. Буддийн шашны

олон ёсыг судлан, эргэл мөргөл явуулах дацанд үсч тэр дундаас Буддийн гол ухааныг судлах тусгай сургууль Гандантэгчилэн буюу Төгс-баясгалант их хөлгөн-ий хийд 1938 оны үед буй болсон. Энэ үеэс хүрээ 30 аймаг, 10 дацан гэж алдаршжээ.

Их хүрээ нь зүүн хүрээ, Гандан, баруун зүүн дамнуурчин /XIX зууны II хагаст үүссэн /Наймаа хот гэх мэт хэдэн хэсгээс бүрдэх болсон байна. Монгол ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн үрээр 1911 онд Богд хаант Монгол улс үүсэхэд монгол орны улс төр, эдийн засаг, шашин соёлын төв нь Их хүрээ болж, 1911 оны 12 дугаар сарын 16-нас эхлэн Их хүрээ нь —Нийслэл хүрээ хэмээгджээ.

Эзэрхэг түрэмгий ба феодалыг эсэргүүцсэн монгол ардын хувьсгал ялж, 1921 оны 7 дугаар сарын 6-нас эхлэн хувьсгалт туг хүрээ нээ үүрд мандсан юм.

Эрх чөлөөгөө байлдан олж, Жаргалант амьдралаа цогцлуулсан Монголын ард түмэн өлгий хотоо хувьсгалт монгол улсын хууль ёсны нийслэл болгон тунхаглалаа. 1924 онд хуралдсан улсын анхдугаар их хурлаас үндсэн хууль батлахад 10-р сарын 20-ний өдөр 14 дугаар хуралдаанаас нийслэл хүрээг —БНМАУ-ийн нийслэл хот хэмээн зарлаж, дорно дахинаа ардын хувьсгалын ач нөлөөг дэлгэрүүлсэн билэг тэмдэг болгон —Улаан хэмээж, Монголын ард түмний олон үеийн баатарлаг тэмцлийн төв ялгуусан хувьсгалын сүр сүлд, хэзээ унтарч мөхөшгүй өрнүүн голомт нь гэснээр — Баатар хот хэмээн нэрлэж шинэ алдар нь орчлон даяар дуурсжээ.

Монголын эртний нийслэл хар хорин хот монголчуудын улс төрийн түүхэнд 400 гаруй жил /XIII- XVII зуун/ гол үүрэг гүйцэтгэсэн бөгөөд эхний 50-ад жилд /1220- 1260-аад онд / Монголын их гүрний төв нийслэл, дараах 100 жилд Монголын Юань улсын Хархорин мужийн төв байгаад түүнээс хойших 200 гаруй жил / 1370-1586/ ар юань улс зүүн Монголын төв хот байв. XVII зууны сүүлчээс Эрдэнэ зуу гэгдэн Халх Монголын төв /1586-1691/ болж явсаар монгол орон Манж улсад эзлэгдэх үед нөлөө холбогдол нь буурчээ.

Орчин үеийн Монголын нийслэл Улаанбаатар хот нь 340-өөд жилийн түүхтэй бөгөөд түүнээс эхний 140-өөд жил /1639- 1778 / Хангай, Хэнтий нуруу, Орхон туул, Хараа голын сав газарт нүүдэллэн явсаар одоогийнхоо нутагт буудаллан 200 жил /1778 оноос хойш/ болоход 150 жил нь /1778- 1911 онд / манж улсын харьяат халх Монгол төв, сүүлийн 60 гаруй жил /1911 оноос хойш/ тусгаар тогтносон монгол улсын нийслэл болжээ. Тэхдээ 1639- 1706 онд өргөө, 1706 1778 онд Их хүрээ, 1911- 1924 онд нийслэл хүрээ, 1924 оноос Улаанбаатар хэмээн нэрлэгдэж ирсэн түүхтэй билээ.

Орчин үеийн монгол улсын нийслэл Улаанбаатар хот нь 340-өөд жилийн түүхтэй бөгөөд үүний эхний 140-өөд жил /1639-1778/ Хангай, Хэнтий нуруу, Орхон, Туул, Хараа голын сав газраар нүүдэллэн явсаар одоогийнхоо нутагт буудаллан 200 жил /1778 оноос хойш/ болоход 150 жил/1778-1911/ Манж улсын харьяат Халх Монголын төв, сүүлийн 60 гаруй жил /1911 оноос хойш/ тусгаар тогтносон монгол улсын нийслэл болсон байна. Тус хот нь 1639-1706 онд —Өргөө, 1706-1778 онд —Их хүрээ, 1911-1924 онд Нийслэл хүрээ, 1924 оноос —Улаанбаатар хот хэмээн тус тус нэрлэгдэж иржээ

Олноо өргөгдсөний 1-р оны өвлийн сүүл сарын 20-онд Дотоод явдлын яамны оруулсан саналаар Богд хааны зарлигаар —Их хүрээ—г —Нийслэл хүрээ гэж нэрлэх болгожээ.

Манж автономит-ийн үеийн монгол улсын засаг захиргааны байгууллагын үүсэл, зохион байгуулалт, үйл ажиллагааны тойм 1691-1921 он,

1921- 7- 5-анд ардын журамт цэрэг болон улаан армийн түрүүч ангиуд нийслэл хүрээг гадаадын түрэмгийлэгчдээс чөлөөлж мөн сарын 8-нд Намын Төв Хороо, ардын түр засгийн газар нийслэл хүрээнд ирж 1921-7-10-анд Богдын засгийн газрыг татан буулгаж, засгийн бүх эрхийг ардын түр засгийн газрын мэдэлд авч, ардын түр засгийн газрыг 5 яамтайгаа байгуулж, 1921-7-11-энд богд гэгээний хэмжээт эрхт хаанд өргөмжлөх ёслол үйлдсэнээр нийслэл хүрээний түүхэн хөгжлийн шинэ үе эхэллээ.

Нийслэл хотын түр захиргаа байгуулах хүртэл нийслэл хүрээний дотоод хэргийг 1921-3-24-нд байгуулагдсан Дотоод яамнаас эрхлэн байсан боловч үнэн хэрэг дээрээ Намын Төв Хороо, Засгийн газраас нийслэлийн өдөр тутмын ажилд ихээхэн анхаарал тавьж, шууд гардан удирдаж байсан байна.

1922 оны 1- дүгээр сарын 25-нд ардын Засгийн газрын шийдвэрээр —олон ноёд тайж нарын хамжлага ба тайж нарыг сум эрийн тоонд шилжүүлэн оруулна, гэж хамжлагат ёсыг халах түүхт шийдвэр гаргасан. Мөн онд хар шар феодалын хамжлага захирах эрхийн тамгыг хураан авсан байна.

1921 оны 7 дугаар сарын 6-анд Монгол ардын намын Төв хороо, Ардын түр засгийн газар нийслэл хүрээнд ирж, засгийн бүх эрхийг Ардын түр Засгийн газрын мэдэлд авч, Засгийн газрыг өргөтгөн байгуулж, Богдын засгийн газрыг татан буулгаснаас хойш, Нийслэл хотын түр захиргаа байгуулах хүртэл, Нийслэл хүрээний дотоод хэргийг Дотоод яамнаас эрхэлж байв.

1923-1924 онд Ардын төлөөлөгчдийн хурал шат дараалан байгуулагдаж, үүгээр төрийн эрх барих хурал хэмээх Ардын төлөөлөгчдийн байгууллагын шинэ систем тогтжээ.

1924 оны 8 дугаар сарын 11-анд Нийслэл хүрээнд —Хотын түр захиргаа байгуулагджээ.

1924 оны 11 дугаар сарын 26-энд Улсын анхдугаар их хурлын 14 дугаар тогтоолоор нийслэл хотын нэрийг —Улаанбаатар хот гэж нэрлэхээр тогтоосон юм.

БНМАУ-ийн 2 дугаар их хурлын 9 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл, Засгийн газрын 22 дугаар тогтоолын 17 дугаар зүйлээр Засгийн газрын комиссын саналыг үндэслэн 1926 оны 9 дүгээр сарын 3-анд Ардын засгийн газрын 35 дугаар хурлын 12 дугаар зүйлээр 1927 оны 1 дүгээр сарын 1-нээ эхлэн хотын захиргааг Дотоод яамны харьяанаас өөрчилж, тусгай эрхтэй, биеэ даасан газар болгохоор тогтоожээ.

1930 онд аймгийн яамыг аймгийн захиргаа гэж нэрлэх болсон ба 1932 оноос дахин аймгийн яам гэж нэрлэжээ.

1931 оны 9 дугаар сарын 21-энд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлаар, Төв аймаг, Улаанбаатар хотын захиргаа, нутаг дэвсгэрийг нэгтгэн төвлөрүүлж, —Улаанбаатар хэмээх аймгийн захиргаа байгуулах, сонгуулийг мөн оны 10 дугаар сарын 1-энд хийхээр тогтоожээ.

1932 оны 8 дугаар сарын 22-онд Сайд нарын Зөвлөлийн 9 дугаар хурлын 3 дугаар зүйлээр Төв аймаг, Улаанбаатар хотын захиргааг салгаж байгуулахаар шийдвэрлэсэн юм.

1937 оны 2 дугаар сарын 13-анд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, СнЗ-ийн хамтарсан 4/2 дугаар тогтоолоор хотын захиргааг өөрчлөн —Нийслэл Улаанбаатар хотыг захирах яам болгохоор тогтоосон байна.

1939 оны 3 сард улсын 22 дугаар бага хурлын тогтоолоор —хотыг захирах яамлхэмээн нэрлэхийг —Улаанбаатар хотын захиргаалхэмээн нэрлэх болсон.

1940 онд батлагдсан БНМАУ-ийн үндсэн хуулиар —Улаанбаатар хотын бага хурлын тэргүүлэгчид хэмээн тогтоосон.

1952 оны 11 дугаар сарын 1-нээ —Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаал хэмээн болжээ.

1962 онд Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа хэмээх болсон.

БНМАУ-ийн АИХ-ийн Тэргүүлэгчдээс 1965 оны 04 сарын 14-ний өдөр гаргасан 79 дүгээр зарлигаар хороодыг татан буулгаж, Улаанбаатар хотод Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдал, гэсэн 4 районыг байгуулсан.

Хотын жинхэнэ захиргаа байгуулсны дараа хот 15 хороонд хуваагдаж байжээ

1925 оны 4-р сард Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хурлаар хотын харьяатыг бий болгожээ.

1927 онд тусгай үнэмлэх бичиг бүхий хотын жинхэнэ харьяат бүрэн бус мэдээгээр өрх 510, ам 1497, түр залрагсдын өрх 4321, ам 11533 байжээ.

1925 онд нийслэл хотын хүн ам 61000 орчим байжээ. Энгийн ба албан ажлын монголчууд 14570, шавилан суугч данстай лам нар 20000, хятад улсын харьяат 23919, зөвлөлтийн харьяат орос болон бусад үндэстэн 1773, бусад гадаад улсын харьяат 644 хүн байжээ.

1926 оны зун хотын хуучин 15 хороог 9 болгон 1928-6-1-энд Улсын 11 дүгээр бага хурлаар Улаанбаатар хотын захиргааны хэргийг эрхлэх газрын тавьсан илтгэл 1928-2-8-нас хотын 9 хороог 6 хороо 133 хориотой болгон тус бүрд дарга, жинхлэн бичээч 1, туслах бичээч2, галч 2, зарлагын орон тоотойгоор байгуулсан хороод нь захиргааны үндсэн байгууллагууд гэжээ.

1930 онд нийслэл хот дахь улс олон нийтийн байгууллагуудад ажиллаж байсан албан хаагчдын тоо 3500 орчим байжээ.

1933-11-21-энд Сайд нарын Зөвлөлийн 36-р тогтоолын 2-р зүйлээр Улаанбаатар хотын ангиудын байгуулалтыг өөрчлөн 6 хороо байгуулахаар тогтоожээ.

1933 онд хотын захиргаанаас хотын хороодыг 6 болгон дахин хувааж, 1935 оноос эхлэн хороодын дарга нарт сумдын даргын нэгэн адил захирах тушаах эрх олгожээ.

1936 онд аж үйлдвэрийн комбинатын 7 дугаар хороог 21 хоринтой байгуулсан байна.

1934-1-12—нд сайд нарын Зөвлөлийн 1-р хурлын 3-р зүйлээр Улаанбаатар хотын хороо, хорины дүрмийг баталжээ.

1937-4-6-энд Ерөнхий сайдын 42-р тушаалд дурдсанаар үзэхэд: Улаанбаатар хот 5 хороотой байсан байна.

1937-6-26-энд Ардын Сайд нарын Зөвлөлийн ерөнхий сайдаас гаргасан 94-р тушаалаар Аж үйлдвэрийн комбинатын орчимд нэг хороо захиргааг шинээр байгуулахаар тогтоожээ.

1938-9-30-энд Сайд нарын Зөвлөлийн 31-р тогтоолын 3-р зүйлээр Улаанбаатар хотын хороо, хорины дүрмийг баталжээ.

1947-12-46-энд УХ-ийн тэргүүлэгчдийн 72 дугаар тогтоолоор Мах комбинатын дэргэд 5 хоринтой, 10 дугаар хороог шинээр байгуулжээ.

1948-2-20-энд УБ-ийн тэргүүлэгчдийн 10-р тогтоолоор Д. Сүхбаатарын нас барсны 25 жилийн ойгоор Улаанбаатар хотын 5 дугаар хороог Сүхбаатарын нэрэмжит болгожээ

1951-2-5-анд Сайд нарын Зөвлөлийн зохион зааварлах хэлтсээс гаргасан бүртгэл мэдээнээс үзвэл:

Улаанбаатар хот нь хороо 10, хорин 141, өрх 1693, хүн ам 55531 байжээ

1952-2-13-анд сайд нарын Зөвлөлийн 25-р тогтоолоор Х.Чойбалсангийн дурсгалыг мөнхжүүлэх зорилгоор их сургуулийн гудамж, Улаанбаатар хотын 3-р хороог Чойбалсангийн нэрэмжит болгожээ.

1952-3-5-анд УИХ-ийн тэргүүлэгчдийн 10 дугаар зарлигаар Улаанбаатар хотод 12 хоринтой, 11-р хороог консулын дэнжид төвлөрүүлэн байгуулжээ.

1956-8-14-энд УИХ-ийн тэргүүлэгчдийн 116 дугаар зарлигаар Улаанбаатар хотын бүх хориодыг татан буулгаж 4000-ас доошгүй хүн тутамд нэг хороо болгон өөрчилж бүгд 30 хороогоор зохион байгуулжээ.

1956-8-31-энд Сайд нарын Зөвлөлийн 446 дугаар тогтоолоор Улаанбаатар хороодыг гүйцэтгэх захиргаа орон тоог -дарга 30

-нарийн бичгийн дарга 30 галч цэвэрлэгч 13-р тогтоон баталжээ.

1957-7-23-анд Улсын их хурлын тэргүүлэгчдийн 114-р зарлигаар Улаанбаатар хотын 30 хороог цомхтгон 10 болгож орон тооны биш 100 хорин-тойгоор шинэчлэн байгуулжээ.

а/ Чингэлтэйн хороо хорин 10

б/ Чойбалсангийн хороо хорин 10

в/ Найрамдлын хороо хорин 15

г/ Сүхбаатарын хороо хорин 10

д/ хоршооллын хороо хорин 10

е/ төмөр замын хороо хорин 10

ё/ ажилтны хороо хорин 11

ж/ Толгойтын хороо хорин 8

з/ амгаланбаатарын хороо хорин 12

н/ уурхайчдын хороо хорин 8

Улаанбаатар хотын засаг захиргааны зохион байгуулал-танд өөрчлөлт оруулсан 1956-8-11-ний зарлигийг хүчингүй болгожээ.

1958-10-18-нд Улсын их хурлын тэргүүлэгчдийн 145-р зарлигаар Улаанбаатар хотын найрамдлын хороо 1959-8-14-энд УИХ-ын тэргүүлэгчдийн 133 дугаар зарлигаар Найрамдлын хорооноос 10-11,12,13,14,15,16 дугаар хорин

Чингэлтэйн хорооноос 9,10-р хорин

Сүхбаатарын хорооноос 5-р хорин

Чойбалсангийн хорооноос 9-р хорин

Эдгээр хорьдыг дээр хи хороодоос хаст бүгд 11 хориныг шилжүүлэн Зүүнсэлбийн хороог шинээр байгуулах.

Хоршооллын хорооны 9-р хорин, Чойбалсангийн 8-р хориныг Төмөр замын хороонд шилжүүлэн Төмөр замын хороог 8 хоринтой болгохоор тус тус тогтоожээ.

1958-10-18-анд Улсын их хурлын тэргүүлэгчдийн 145-р зарлигаар Улаанбаатар хотын найрамдлын хороонд 1, ажилчны хороонд 1, тус тус шинээр нэмэн байгуулжээ.

1959-8-14-энд Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн 133 дугаар зарлигаар Зүүнсэлбийн захиргааг 11 хорин тойгоор шинээр байгуулжээ

1960-12-30-энд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 258 дугаар зарлигаар БНМАУ-ийн үндсэн хуулиуд зааснаар сум хороодын АДХ-ийн засаг захиргааны нэгж болсныг үндэслэн Улаанбаатар хотын хорьдыг татан буулгажээ.

-4-17-энд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 82 дугаар зарлигаар Улаанбаатар хотын Гачууртын сангийн аж ахуйд хороо захиргаа байгуулжээ.

1962-12-6-анд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 202 дугаар зарлигаар Налайх хотод харьяалуулан Хонхор, Горькийн хороо захиргаанд тус тус байгуулжээ.

1964-7-29-анд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 135 дугаар зарлигаар Улаанбаатар хотын харьяа Гачууртын хороо захиргааг Төв аймагт шилжүүлэн харьяалуулжээ.

1965-4-14-анд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 79 дүгээр зарлигаар Нийслэл Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын харьяа Ажилчин, Найрамдал, Амгалан, Зүүн сэлбэ, Сүхбаатар, Хоршоолол, Чингэлтэй, Толгойт, Октябрь, Төмөр замын хороог татан буулгаж, Сүхбаатар, Октябрийн, Ажилчин, Найрамдлын районыг байгуулж Улаанбаатар хотын районы АДХ-ийн сонгуулийг орон нутгийн хурлын 7 дахь удаагийн ээлжит сонгуультай хамтатган явуулахаар тогтоожээ.

1965-12-9-энд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 250 дугаар зарлигаар Налайх хотыг район эрхтэйгээр Улаанбаатар хотод харьяалуулж Налайх, хотын харьяаны хонхор, Горхин хороодыг татан буулгажээ.

Улаанбаатар хот, район, сангийн аж ахуй 1965 оны байдлаар хот район сангийн аж ахуй

- 1.Ажилчны район
- 2.Сүхбаатарын район
- 3.Найрамдлын район
- 4.Октябрийн район
- 5.Налайх хот
- 6.Амгалангийн сангийн аж ахуй
- 7.Төр хурахын сангийн аж ахуй
- 8.Халиун бугын сангийн аж ахуй

1968-6-14-энд Сайд нарын Зөвлөлийн 201-р тогтоолоор Улаанбаатар хотын

-Сүхбаатарын район орон тоо 35

-Найрамдлын район орон тоо 28

-Ажилчны район орон тоо 28

-Октябрийн район орон тоо 28

-Налайх хот орон тоо 24

Бүгд орон тоогоор 143

Район тус бүрийг санхүүгийн хэлтэс, Ардын боловсролын хэлтэстэйгээр тогтоон баталжээ.

1968-6-14-нд Сайд нарын Зөвлөлийн 301-р тогтоолоор Улаанбаатар хотын районы ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаанд зохион байгуулалтыг

-Санхүүгийн хэлтэс

-Ардын боловсролын хэлтэс /нягтлан бодох ангитай/ бүгд 143 нэгжээр тогтоон баталжээ.

-Сүхбаатар

-Найрамдал

-Ажилчин

-Октябрь

-Налайх зэрэг районууд байсан.

1971-2-19-энд Сайд нарын Зөвлөлийн 46-р тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаа, 4 районы гүйцэтгэх захиргаанд зохион зааварлах хэлтсийн даргын орон тоог бий болгохоор тогтоожээ.

1972-4-28-нд Сайд нарын Зөвлөлийн 161-р тогтоолоор Сүхбаатар, Найрамдал, Ажилчны районы гүйцэтгэх захиргаанд хот тохижуулах хэлтэс байгуулах тогтоожээ.

1974-1-7-энд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 2 дугаар зарлигаар Төв аймгийн Гачуурт сумыг хороо болгон өөрчлөн байгуулж Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд харьяалуулжээ. 1977-3-16-анд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 64-р зарлигаар Улаанбаатар хотын —Партизан сангийн аж ахуйг харьяалсан Партизаны хороо, төв нь —Жаргалант шинээр байгуулжээ.

1975-2-27-энд Сайд нарын Зөвлөлийн 104-р тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны зохион байгуулалтыг дор дурдсанаар баталжээ.

а/ Зохион зааварлах хэлтэс

б/ Санхүүгийн хэлтэс

в/ Төлөвлөгөөний комисс

г/ Хөдөлмөр, нийгэм хангамжийн хэлтэс

д/ Статистикийн товчоо

е/ Хөдөө аж ахуйн хэлтэс

ж/ Эрүүлийг хамгаалах газар

з/ Ардын боловсролын хэлтэс

и/ Соёлын хэлтэс

к/ Цэрэг иргэний хамгаалалтын хэлтэс

л/ Аж ахуйн хэлтэс орон тоог 89 нэгжээр тогтоожээ.

1978-9-11-нд Сайд нарын зөвлөлийн 294-р тогтоолоор Улаанбаатар хотын АДХ-ийн гүйцэтгэх захиргааны орон тоог 102 нэгжээр, зохион байгуулалтыг

а/ Зохион зааварлах хэлтэс

б/ Санхүүгийн хэлтэс

в/ Төлөвлөгөөний комисс

г/ Статистикийн товчоо

д/ Ардын боловсролын хэлтэс

е/ Хөдөлмөр нийгэм хангамжийн хэлтэс /гадаадын харьяат иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцах тасагтай/

ж/ Орон сууц, нийтийн үйлчилгээний хэлтэс

з/ Цэрэг иргэний хамгаалалтын хэлтэс

и/ Их барилгын хэлтэс

к/ Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх хэлтэс

л/ Соёлын хэлтэс

м/ Эрүүлийг хамгаалах газар

н/ Хөдөө аж ахуйг удирдах газар

о/ Аж ахуйн хэлтэстэйгээр баталжээ.

1989 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн Сайд нарын Зөвлөлийн 152 дугаар тогтоолоор Улаанбаатар Хотын Ардын депутатуудын хурлын Гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтыг дарга 1, нэгдүгээр орлогч 1, Орлогч дарга 1, /Нийгэм соёл эрхэлсэн, барилгын асуудал эрхэлсэн, орон сууц, нийтийн аж ахуй, хот тохижуулах эрхэлсэн/ хариуцлагатай нарийн бичиг 1 тус тус батлаад аппаратын бүтцийг нь

Зохион зааварлах хэлтэс

Төлөвлөгөө, Эдийн засгийн хэлтэс

Санхүүгийн хэлтэс/ хянан байцаах тасагтай/

Хөрөнгө оруулалтын хэлтэс

Хөдөлмөр зохицуулах товчоо

Цэргийн хэлтэс

Аж ахуйн хэлтэс

Хууль зүй арбитрын хэлтэс Соёлын хэлтэс

Орон сууц хуваарилалтын тасагтай байхаар тогтсон

Улаанбаатар хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны харьяанд

Ардын боловсролын хэлтэс

Ахуйн үйлчилгээний Удирдах газар

Байгаль Орчныг хамгаалах газар

Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар

Тээврийг удирдах газар

Хот тохижуулах газар

Ус сувгийн ашиглалтыг Удирдах газар

Хөдөө аж ахуйг удирдах газар

Телефон радио, ашиглалтын хороо

Эрүүлийг хамгаалах газар

Нийтийн хоолны удирдах газар

Биеийн тамир спортын газар

Аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдэл зэргийг ажиглуулахаар тогтоосон

1989 оноос өмнө аймаг, хотын хурал, гүйцэтгэх засаглал/ хоёр/ нь нэг даргатай байсан ба 1989 оноос хойш Монгол Улсын аймаг, хотын хурал биеэ даан /орон тооны бус/ даргатай, тэргүүлэгчидтэй болжээ.

1989-1990 Улаанбаатар хотын Ардын Депутатуудын хурлын Тэргүүлэгчдийн хурал 225 депутат, 15 тэргүүлэгчтэй байсан. 1990 оны 01 дүгээр сараас УБХ-ийн Ардын хурал гэх болсон. 1990 оны 07 дугаар сар хүртэл ажиллаж байсан тэр үед хурал 225 депутат, 15 тэргүүлэгчтэй байв.

Сайд нарын зөвлөлийн 1990 оны 06 дугаар сарын 08-ны 297 дугаар тогтоолоор УБХ-ийн АДХГЗ-ний Удирдлагын орон тоог дарга 1, нэгдүгээр орлогч дарга 1, орлогч дарга 4 байхаар тогтоов.

Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргааны аппаратын бүтцийг тогтоосон.

Нийгэм, Эдийн засгийн хөгжлийн хэлтэс

Хүн ам зүй, Хөдөлмөрийн хэлтэс

Санхүүгийн хэлтэс

Хот байгуулалтын хэлтэс

Цэрэг Иргэний хамгаалалтын хэлтэс

Материал хангамжийн хэлтэс

Хэрэг эрхлэх хэлтэс

Орон сууц хуваарилалтын тасаг гэж байсан.

1992 оны 25-р тогтоолыг үндэслэн Нийслэл хотын 4 районыг 6 болгож, Хотын АДХ-ийн гүйцэтгэх захиргааг Нийслэл хотын Засаг даргын тамгын газар болгон орон тоо зохион байгуул алтанд доорх өөрчлөлтийг хийжээ. Үүнд

Удирдлагын хэлтэс

Засаг захиргааны хэлтэс

Санхүүгийн хэлтэс

Цэрэг Иргэний хамгаалалтын хэлтэс

Нийгэм эдийн засгийн бодлогын хэлтэс

Хүн амын бодлогын хэлтэс

Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс

Статистик мэдээллийн хэлтэс

Хянан байцаах хэлтэс

Орон сууц хуваарилалтын хэлтэс

Төлөөлөгчдийн хурлын ажлын алба гэсэн үндсэн зохион байгуулалтай болжээ.

Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 25 дугаар тогтоолоор Монгол улсын /шинэ/ Үндсэн хуулийн жаран нэгдүгээр зүйлийн 4, Засаг

захиргаа , нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн хорин наймдугаар зүйлийн 1, 3 дугаар заалтыг үндэслэн Нийслэлийн Удирдлагын Засаг даргаас гадна Засаг даргын орлогч 4, Тамгын газрын дарга бөгөөд Засаг захиргааны хэлтсийн дарга 1 байх, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дор дурдсан хэлтэс тасагтай байхаар тогтоов. Үүнд:

Засаг захиргааны хэлтэс

Санхүүгийн хэлтэс

Цэрэг иргэний хамгаалалтын хэлтэс

Статистик мэдээллийн хэлтэс /тооцоолох төвтэй/

Нийгэм, эдийн засгийн бодлогын хэлтэс

Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс

Хүн амын бодлого, хөдөлмөрийн хэлтэс

Хянан байцах хэлтэс

Орон сууц хуваарилалтын тасаг

Нийслэлийн Засаг даргын дэргэд дор дурдсан газар, хэлтэс алба байхаар тогтоосон Үүнд:

Хот байгуулалт, төлөвлөлтийн газар

Барилга, хөрөнгө оруулалтын газар

Цагдаагийн газар

Байгаль орчны газар

Хот тохижуулах газар

Хүнс, хөдөө аж ахуйн газар

Шинжлэх ухаан, боловсролын газар

Эрүүл мэндийн газар

Соёл, олон түмний ажлын хэлтэс

Залуучууд, спортын хороо

Хууль зүйн газар

Өмчийн газар

Татварын алба эдгээ болно.

Ийнхүү орон нутгийн удирдлагын тогтолцоо 1992 онд батлагдсан үндсэн хуулиар цоо шинэ бүтэцтэйгээр хуульчлагдсан билээ. Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлгийн тавин есдүгээр зүйлд" Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ гэж заасан билээ.

1994 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн Монгол Улсын Их хурлаар "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тухай "Монгол улсын Засгийн газрын 1994.оны 12 дугаар сарын 28-ний өдрийн 229 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албыг тусад нь зохион байгуулан ажиллуулах болсон нь засаг захиргаа, аж ахуйн үйлчилгээний ажлын ялгаа заагийг тогтооход чухал ач холбогдолтой болсон.

Нийслэлийн засаг даргын /ажлын алба буюу/ Тамгын газар нь

Засаг захиргааны хэлтэс

Санхүүгийн хэлтэс

Цэрэг, Иргэний хамгаалалтын хэлтэс

Эдийн засаг, нийгмийн бодлогын хэлтэс

Хянан байцаах хэлтэс

Статистик мэдээллийн хэлтэстэйгээр ажиллаж байв.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 263 тоот тогтоолоор Нийслэлийн Удирдлагыг Засаг даргаас гадна Засаг даргын орлогч 1, Засаг даргын Тамгын газрын бүтцийг доорх байдлаар тогтоосон.

Үүнд:

Төрийн Захиргааны удирдлагын хэлтэс

Стратегийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтэс

Нийгмийн бодлогын хэлтэстэй байхаар тогтоосон.

1997 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 246 дугаар тогтоолоор "Гадаад харилцааны хэлтсийг нэмж байгуулсан.

1998 оны 27 дугаар тогтоолоор Статистик мэдээлэл Судалгааны алба, 124 дүгээр тогтоолоор "Архивын алба" 1999 оны 206 дугаар тогтоолоор "Цэрэг Иргэний хамгаалалтын штаб" гэсэн хэрэгжүүлэгч агентлагуудыг байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 11дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтол гарч Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг нь:

Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

Эдийн засаг, стратегийн бодлогын хэлтэс

Санхүүгийн бодлогын хэлтэс

Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс

Хууль зүйн хэлтэс

Гадаад харилцаа хамтын ажиллагааны хэлтэстэй байхаар тогтоож, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэд Төрийн захиргааны даргын үүргийг давхар хариуцуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 09 дүгээр сарын 08-ний өдрийн 201 дүгээр тогтоолоор Нийслэлийн Засаг даргын тамгын газрын бүтцийг нь:

Төрийн Захиргаа хууль зүйн хэлтэс

Стратеги бодлого, төлөвлөлтийн хэлтэс

Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс

Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс

Цэргийн болон гамшгаас хамгаалах штаб НЗДТГ-ын орон тооны дээд хязгаарыг 60 хүртэл тогтсон.

2004 оны Засгийн газрын 182 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг нь: Төрийн захиргааны удирдлагын хэлтэс / Олон нийттэй харилцах албатай/

Хотын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс

Нийгмийн хөгжлийн хэлтэс

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс

Цэргийн штаб

Хууль зүйн хэлтэс

Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс гэсэн 8 хэлтэс 75 хүртэл орон тоотойгоор ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 1 дүгээр сарын 19-нд 15 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг нь:

Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /олон нийттэй харилцах болон хяналт-шинжилгээ үнэлгээний албатай/

Хотын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Нийгмийн хөгжлийн хэлтэс

Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс

Хууль зүйн хэлтэс

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс

Цэргийн штаб зэрэг 7 хэлтэс 70 орон тоотой баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн "Нийслэлийн Засаг даргын 22 тоот захирамжаар Захирагчийн Ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоосон Захирагчийн ажлын алба нь :

а/ Инженерийн байгууламжийн хэлтэс

б/ Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс

в/ Хот нийтийн аж ахуйн хэлтэс

г/ Аялал жуулчлалын хэлтэстэйгээр ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дүгээр сарын 24-нд 68 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг нь: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Засаг даргын орлогч /Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан/ Нийслэлийн Засаг даргын орлогч /Барилга, хот байгуулалт, дэд бүтцийн асуудал хариуцсан/ Нийслэлийн Засаг даргын орлогч /Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан/ Нийслэлийн Засаг даргын орлогч Үйлдвэрлэл, экологийн асуудал хариуцсан/ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалтыг нь

Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

Санхүү, төрийн сангийн хэлтэс

Нийгмийн хөгжлийн хэлтэс

Хотын хөгжлийн бодлогын хэлтэс

Үйлдвэрлэлийн хэлтэс

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс

Хууль зүйн хэлтэс

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс

Цэргийн штаб

Хэвлэл, мэдээллийн алба зэрэг 85 орон тоотойгоор баталсан бүтцээр одоог хүртэл ажиллаж байна.